



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/612

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 2021 оны 10 дугаар сарын 04-ий өдрийн 58 дугаар зарлиг, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын 3.3.4, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Аймгийн 2021 оны төсөв батлах тухай” 2020 оны 03/07 дугаар тогтоолын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих мод, бутны хамгаалалтын ажилд шаардагдах хоёрдогч түүхий эд боловсруулж хийх хашааны шон нийлүүлэх ажилд зарцуулах 18,000,000 (арван найман сая) төгрөгийг нэгдүгээр хавсралтаар, аялал жуулчлалын өвлийн эвент арга хэмжээ “KHARAKHORUM ICE FESTIVAL-2021” мөсөнд авиралтын цомын аварга шалгаруулах тэмцээний арга хэмжээнд зарцуулах 3,000,000 (гурван сая) төгрөгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хавсралтаар батлагдсан 18,000,000 (арван найман сая) төгрөгийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас, 3,000,000 (гурван сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд), аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Г.Баясгалан) нарт зөвшөөрсүгэй.

3.Дээрх ажлуудыг гүйцэтгэх аж ахуйн нэгж, байгууллагатай холбогдох хууль журмын дагуу гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Г.Баясгалан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101293

Аймгийн Засаг даргын 2021 оны 18
дугаар сарын 14-ны өдрийн 47612-
дугаар захирамжийн нэгдүгээр
хавсралт



ХАШААНЫ ШОН НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН
ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хашааны шон	ширхэг	3600	5000	18000,000
Нийт зардал					18000,000

- оОо -

Аймгийн Засаг даргын 2021 оны 12
дугаар сарын 11-ны өдрийн 11/618
дугаар захирамжийн хоёрдугаар
хавсралт



"KHARAKHORUM ICE FESTIVAL-2021" МӨСӨНД АВИРАЛТЫН
ЦОМЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЗАРДЛЫН
ТООЦОО

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Нийт үнэ
1	Хулдаасан хэвлэл /том/	ш	2	450,000	900,000
2	Шагнал	ш	12	-	1,980,000
3	Өргөмжлөл	ш	12	2,500	30,000
4	Авто стикер	ш	6	5,000	30,000
5	Цомтой хамт гардуулах батламж	ш	2	15,000	30,000
6	Олс	ш	1	30,000	30,000
Нийт зардал					3000,000